

Ш	33	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт	Хэрэгжилтын явц	Үнэлгээ %
<b>ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО</b>				
<b>МУ-ын хууль</b>				
1	1	<b>ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ</b> 2015-07-09 11.2 11.2.Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 193 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд олгогдох дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавих журам”-ууд тус тус батлагдсан. Мөн Аж үйлдвэрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2016 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 115/А/282 тоот тушаалаар “Аж үйлдвэрлэлийн салбарын технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам” батлагдсан.	100
2	2	<b>ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ</b> 2015-07-09 14.3 14.3.Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн тухайн жилийн төсвийн хуваарийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Үйлдвэрлэлийг дэмжих сангийн зориулалтаар Аж үйлдвэрийн сайдын 2016 оны багцад 5,0 тэрбум төгрөг тусгагдсан. Гэвч 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж Аж үйлдвэрийн яам татан буугдаж, хүнд үйлдвэрийн хөгжлийн асуудал Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд багтсан. Гэсэн хэдий ч Аж үйлдвэрийн сайдын 2016 оны багцад тусгагдсан 5,0 тэрбум төгрөг УУХҮС-ын багцад шилжиж ирээгүй. Мөн 2017 оны Улсын төсөвт үйлдвэрлэлийг дэмжих сангийн зориулалтаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад хөрөнгө тусгагдаагүй болно.	/-/
<b>УИХ-ЫН ТОГТООЛ</b>				
1	1	<b>Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай</b> 2010-02-04 3.3 Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажил эхлүүлэх.	1. Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ны өдөр 171 дугаар тогтоолоор Дархан газрын тос боловсруулах үйлдвэрийн төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгчидтэй тохиролцоо замаар 51 ба түүнээс ба үйлдвэрийн гэрээ, дүрэмд өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Төрийн өмчийн хорооны дарга Д.Цогтбаатар нарт даалгасан. Энэхүү тогтоолын хүрээнд Төрийн өмчийн хороо 2013 оны 6 дугаар сард 384 тоот тогтоол гаргаж Дархан газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг 51 хувь болгох, компанийг үүсгэн байгуулах гэрээ болон компанийн дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан. 2. Төрийн өмчийн хорооны 384 дүгээр тогтоолын дагуу Дархан газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2013 оны 07 дугаар сарын 26-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн 2-р хуралдаанаар Төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг 51, Монголсэкию ХХК-ийн өмчийн эзэмшлийн хувь хэмжээг 49 болгож шийдвэрлэсэн байна. Дархан газрын тос боловсруулах үйлдвэрийн техникийн зураг төслийн ажлыг гүйцэтгэх болон төлбөрийн тухай гэрээг Уул Уурхайн яам, Дархан газрын тос боловсруулах үйлдвэр ХХК болон Тоёо инженеринг корпорацийн хооронд 2013 оны 5 дугаар сард байгуулж, гэрээний дагуу Тоёо инженеринг корпораци Техникийн зураг төслийг боловсруулж 2014 оны 2 дугаар сард Уул уурхайн сайдын 2014 оны 79 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байна. Япон улсад 2014 оны 2 дугаар сард Монгол улсын Уул уурхайн яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны төлөөлөл оролцсон ажлын хэсэг болон Япон улсын Олон улсын Хамтын ажиллагааны банкны хооронд дахин уулзалт болсон. Тус уулзалтаар энэхүү төслийн санхүүжилтэд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргаж өгөх асуудлыг хэлэлцсэн. Тоёо инженеринг компани нь үйлдвэрийг барьж байгуулах, түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг хэрэгжүүлэх байсан боловч цаашид ажлыг үргэлжлүүлэхээс татгалзсан учир Дархан газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь Япон улсын Чиёда компанид энэ ажлыг хийх саналыг тавьсан байна. Чиёда компани нь Тоёо инженеринг компанийн боловсруулсан техникийн зураг төслийг ашиглахгүй, өөрсдийн тооцоо судалгаанд үндэслэн дахин боловсруулах, үүнд шаардагдах 2,3 сая ам долларыг Монгол улсын Засгийн газраас гаргаж өгөх хүсэлтийг 2014 оны 7-р сард Уул уурхайн яаманд тавьсан.	70
1	2	<b>Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай</b> 2010-02-04 4. зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэл ажлыг 2011 оны эхний хагас жилд багтаан хангах.	ЭБЭХ-ны сайдын 2010 оны 162 дугаар тушаалаар Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барьж байгуулах боломж, нөхцөлийн талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, УИХ-ын ЭЗБХ-ны 2010 оны 5-р сарын 18 өдрийн хуралдаанд ЭБЭХЯ-ны сайд Д.Зоригт энэ тогтоолын хэрэгжилтын талаар мэдээлэл хийж, ажлын хэсгийн дүгнэлтээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрлэж буй зэсийн баяжмалд түшиглэн жилд 90-130 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг Ausmelt болон Isasmelt технологиор, “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд жилд 200 мянган тонноос дээш катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг барихдаа Финлянд улсын “Outotec” компанийн Flashsmelt технологийг сонгох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд технологийн эцсийн сонголтыг нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлно.	70

2	<p>3 <b>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах тухай</b> 2010-04-29</p> <p>3. зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга, хэлбэрийг тодорхойлох;</p>	<p>УИХ-ын тогтоол, Засгийн газрын шийдвэр гарсны дараа ЭБЭХ-ны сайд 2010 оны 162 дугаар тушаал гарган Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барьж байгуулах боломж, нөхцөлийн талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, УИХ-ын ЭЗБХ-ны 2010 оны 5-р сарын 18 өдрийн хуралдаанд ЭБЭХЯ-ны сайд Д.Зоригт энэ тогтоолын хэрэгжилтын талаар мэдээлэл хийж, ажлын хэсгийн дүгнэлтээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрлэж буй зэсийн баяжмалд түшиглэн жилд 90-130 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг Ausmelt болон Isasmelt технологиор, “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд жилд 200 мянган тонноос дээш катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг барихдаа Финлянд улсын “Outotec” компанийн Flashsmelt технологийг сонгох нь зүйтэй гэж үзсэн бөгөөд технологийн эцсийн сонголтыг нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлно.</p>	50
3	<p>4 <b>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай</b> 2015-02-17</p> <p>10 10/цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;</p>	<p>“Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах” зорилтын хүрээнд, “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь Төмөртолгой, Төмөртэй, Хуст-Уулын төмрийн хүдрийн ордуудаа түшиглэн төмрийн хүдрийг боловсруулж, төмөрлөг түүхий эдийн хомсдлыг багасгах, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг ихэсгэх, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх, “Уул уурхай металлургийн цогцолбор” байгуулахаар ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) болон Олон улсын хөгжлийн нийгэмлэг (Дэлхийн банк)-ийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (УУДБХОД)-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дараахь ажлууд хийгдэж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” –ийн төслийн Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах</li> <li>2. “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийх</li> <li>3. “Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах” төслийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах,</li> <li>4. Мөн “Хар төмөрлөгийн цогцолбор”-ын “Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ” хийх.</li> </ol> <p>Дээрхи ажлуудын хүрээнд төслийг хэрэгжүүлэх, зөвлөх компаниудыг “Дэлхийн банкны зээлдэгчид зөвлөх сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ын дагуу сонгон шалгаруулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 сарын 06-ны өдрийн 273 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл” –ийн Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөхийг шалгаруулах тендерыг зарлан, 2 шаттайгаар зохион шалгаруулан (2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр тендерыг нээж шалгаруулсан) Канадын “Hatch” компани шалгарсан ба АҮЯ-тай 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. ТЭЗҮ нь 12 сарын хугацаанд хийгдэж, 2017 оны 05 дүгээр сард эцсийн тайлангаа хүлээлгэн өгнө.</li> <li>2. Аж үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн “Үнэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай” 273 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх зөвлөхийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2015 оны 11 сарын 18-ний өдөр зарлаж 2 шатны үнэлгээ хийж 2016 оны 03 сарын 11-ны өдөр “Экотон” ХХК компани шалгарсан ба 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр АҮЯ-тай гэрээ байгуулсан ба БОННУ хийх ажил 12 сар үргэлжилнэ..</li> <li>3. Аж үйлдвэрийн яамны ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөхийг шалгаруулах 2 шатны сонгон шалгаруулалтыг явуулж БНХАУ-ын “Wuhuan engineering” компани шалгарсан ба АҮЯ-тай гэрээ хийн ТЭЗҮ-ийг боловсруулж байна. ТЭЗҮ хийх ажил 15 сар үргэлжилнэ.</li> <li>4. Мөн “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төслийн БОННУ-ний гүйцэтгэгчээр шалгарсан Монгол улсын “Green trends” ХХК-иудтай АҮЯамны ТНБД төслийн ажил гүйцэтгэх гурвалсан гэрээг 2016 оны 3-р сарын 23-ний өдөр байгуулсан ба “Green trends” ХХК нь төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж байна. БОННУ-ны ажил гэрээ байгуулснаас хойш 12 сар хийнэ.</li> </ol>	50
5	<p><b>Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай</b> 2015-06-19</p> <p>2.1 1/бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги хөтөлбөрийг таван жилээр төлөвлөж, холбогдох төлөвлөгөө, төслийг боловсруулан баталж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах;</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 396-р тогтоолоор “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах дунд хугацааны стратеги төлөвлөгөө” батлуулсан. (2015-2020 он)</p>	100

4	6	<b>Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай</b> 2015-06-19  2.2 2/бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 4-ны өдрийн 193 тоот тогтоолоор “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд олгогдох дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавих журам”-ыг тус тус батлуулсан.	100
	7	<b>Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай</b> 2015-06-19  2.3 3/энэ тогтоолын 2 дахь заалтын 1-д заасан стратеги хөтөлбөр, төлөвлөгөө, төслийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд холбогдох асуудлуудыг тусган ажиллаж байна.	100
	8	<b>Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай</b> 2015-06-19  2.4 4/дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээмж болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах.	“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 7 дугаар бүлгийн 7.3-д бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ гэж заасан ба нэгдүгээр үе шатны үнэлгээ 2020 онд хийгдэнэ.	/-/

### Ерөнхийлөгчийн зарлиг

1	1	<b>Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай</b> 2015-01-29  1/ 1/Аж үйлдвэржилттэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн, эдийн засгийн нөөц, чадамжид тулгуурлан богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогын нэгдсэн баримт бичгийг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчинг бүрдүүлэх;	УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоолын хавсралтаар "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого", 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн УИХ-ийн чуулганаар “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” хууль батлагдсан.	100
	2	<b>Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай</b> 2015-01-29  2/ 2/Экспорт болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжсэн татварын уян хатан ухаалаг бодлого явуулах. Ингэхдээ дотоодод үйлдвэрлэсэн хийц бүтээгдэхүүнийг дараагийн боловсруулах үйлдвэрт шилжүүлэх сонирхлыг төрүүлэхүйц татвар, гаалийн тарифын бодлого явуулж, кластерын тогтолцоог бүрдүүлэх;	Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Гаалийн тарифын зөвлөлийн 2015 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. МУ-ын Засгийн газраас УИХ-ын хаврын чуулганы 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлагдсан “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийг дагалдан хэлэлцүүлсэн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах” тухай УИХ-ын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай УИХ-ын 74 дугаар тогтоол гарсан. Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны хуралдаан (332 дугаар тогтоол)-оор 3 нэр төрлийн, 10 гаруй барааны импортын барааны гаалийн тарифыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд: Мах, дайвар мах (адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ), зөгийн бал, нөөшилсөн бүтээгдэхүүн, цемент, троллейбус гэх мэт. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар экспортод гаргасан зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнд /ноос, ноолуур, арьс шир болон бусад/ албан татварын хувь хэмжээг “0”-ээр тогтоох, үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй ноос, ноолуурыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол худалдан авсан этгээдийн төлөх НӨАТ-аас хасч тооцох зохицуулалтыг нэмсэн.	100

		<b>Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай</b> 2015-01-29	2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр "Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хууль УИХ-аар батлагдсан.	100
3		8/ 8/Геологи, уул уурхайн салбарын хөгжлийн өнөөгийн түвшин нь их төлөв ашигт малтмалыг эрж хайх, олборлох, баяжуулах төдийгөөр хязгаарлагдаж байгаад дүгнэлт хийж, боловсруулах болон нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах, үүсмэл ордыг ашиглах эрх зүйн таатай орчин бий болгох.		
<b>ЗГ-ын ТОГТООЛ</b>				
1	1	<b>Журам, чиглэл батлах тухай /Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай/</b> 2011-04-06	Засгийн газрын 2011 оны "Өмнийн говийн бүтээн байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 257 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны "Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор төслийн талаар авах арга хэмжээний тухай" 216 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны "Сайншандын аж үйлдвэрийн Цогцолбор байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 76 дугаар тогтоол тус тус гарсан. Төрийн өмчийн хорооны 2012 оны 495 дугаар тогтоолоор "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолборын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий "САҮЦ" нэртэй Төрийн өмчит ХХК-ийг байгуулж, ТӨХ-ны 2013 оны 107-р тогтоолоор төрийн эзэмшлийн хувийг 34% байхаар шийдвэрлэсэн. САҮЦ-ийн хуулийн, ерөнхий гэсэн 2 зөвлөх үйлчилгээ авсан ба байгаль орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээ, суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөлтөд 14.1 тэрбум төгрөгийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлэж үүний 9,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр дээрх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Дорноговь аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/325 тоот захирамжаар Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 3512.5 га газрыг "Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор" Төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компанид эзэмшүүлэх А/325 тоот захирамжаар гэрчилгээг 15 жилийн хугацаатай САҮЦ ХК-д олгосон.	100
2	2	<b>Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай</b> 2012-12-21	"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын "Volant Industry" компани болон Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төсөл боловсруулах институт /ENFI/ "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан техник- эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) боловсруулсан ба уг ТЭЗҮ-ийг Аж үйлдвэрийн салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газрын 2016 оны "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх олгох тухай" 318 дугаар тогтоол батлуулсан. Дээрхи тогтоолоор "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нийт хувьцааны" 10 (арван) хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших тухай Аж үйлдвэрийн яамны саналыг зарчмын хувьд зөвшөөрч, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх, мөн хөрөнгө оруулагчийг сонгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг тус яаманд даалгасан.	100
	3	<b>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай</b> 2014-10-25	Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт "Баянговь нутаг" үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах асуудлыг Засгийн Газрын 2015 оны 5 дугаар сарын 18 – ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 193 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. 2015 оны 8 дугаар сард Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ паркийн удирдлагатай гэрээ байгуулан ажилласан. 2015 оны 10 дугаар сард "Монгол-Хятадын анхдугаар экспо"-д хэлэлцэх асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд "Баянговь нутаг" паркийн асуудлыг оруулсан бөгөөд экспогийн үеэр Тус паркийн удирдлага БНХАУ-ын Чинхуа групптэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. <input type="checkbox"/> Багануур дүүрэгт үйлдвэрлэл, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах асуудлыг Засгийн Газрын 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 272 дугаар тогтоолоор үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөллийг олгосон. Аж үйлдвэрийн яам/хуучнаар/ нь паркийн удирдлагатай 2016 оны 6 дугаар сард гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлсэн.	50

3	4	<p><b>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай</b> 2014-10-25</p> <p>3 Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл авснаас хойш тодорхой хугацааны дараа техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын үндэслэл, судалгаа зэрэг хуульд заасан шаардлагыг танилцуулсны үндсэн дээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх тухай үүрэг хүлээлгэх журмыг эрх зүйн үндэслэлийн хамт боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндоржид үүрэг болгосугай.</p>	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлагыг тодорхой заасан байдаг.</p> <p>Гэтэл Засгийн газрын энэхүү тогтоолын заалт нь УТП-ын эрх зүйн байдлын тухай хуулийн дээрх заалттай зөрчилдөж байгаа болно. Энэ талаар Хууль зүйн яамнаас амаар тодруулга авсан бөгөөд үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахгүйгээр журмаар зохицуулах боломжгүй гэсэн тайлбар өгсөн.</p>	-/-
4	5	<p><b>Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай</b> 2015-03-23</p> <p>2 Газрын тос боловсруулах үйлдвэрүүдийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүнг 2015 оны III улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.</p>	<p>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эд дээр түшиглэн байгуулах чиглэлийг Засгийн газарт 2014 онд өгч улмаар Засгийн газраас 2015 онд “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 113 дугаар тогтоолыг баталж, олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд Унгар улсад бүртгэлтэй Евройл компаниар “Говийн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл”-ийг 2015 оны 7-р дугаар сараас 2016 оны 2 дугаар сарын хооронд боловсруулж бэлэн болгосон.</p> <p>Урьдчилсан ТЭЗҮ-ийг Аж үйлдвэрийн яамны /хуучнаар/ Хүнд үйлдвэрийн салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авч Засгийн газарт танилцуулсан.</p>	100
5	6	<p><b>Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай</b> 2015-05-18</p> <p>2 Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатарт, хэлэлцээ хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад тус тус даалгасугай.</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Зүүн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн концесс олгох /шалгаруулах/ үүрэг бүхий Ажлын хэсэг 2015 оны 6 дугаар сард Хөрөнгө оруулалтын газар дээр байгуулагдаж, концессийн сонгон шалгаруулалтыг 9 дүгээр сарын 1-нд зарласан. Уг уралдаант шалгаруулалтад материал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдээс хураангуй жагсаалт үүсгэж санал болгосон техник, технологийг үйлдвэрт нэвтэрч, туршигдсан байдлыг судлан үзэж үнэлэлт, дүгнэлт өгөх дэд ажлын хэсгүүдийг Аж үйлдвэрийн яаман дээр байгуулсан. Энэхүү дэд ажлын хэсгүүд ажиллан тус тусын санал, дүгнэлтийг боловсруулж Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын газар хураангуй жагсаалтад орсон компаниудаас санхүүгийн санал, бизнесийн төлөвлөгөөг авахаар ажиллаж байсан боловч тус хороо 2016 оны УИХ-ын сонгуулийн дараагаар татан буугдсан.</p>	70
6	7	<p><b>Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай</b> 2015-06-15</p> <p>2 Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулан төр, хувийн хэвшлийн оролцооны хувь хэмжээг тогтоож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг сонгон хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийлгэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд тус тус даалгасугай.</p>	<p>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын “Volant Industry” компани болон Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төсөл боловсруулах институт /ENFI/ “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан техник- эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) боловсруулсан ба уг ТЭЗҮ-ийг Аж үйлдвэрийн салбарын ШУТЗ-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн.</p> <p>Засгийн газрын 2016 оны “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх олгох тухай” 318 дугаар тогтоол батлуулсан.</p> <p>Дээрхи тогтоолоор “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нийт хувьцааны” 10 (арван) хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших тухай Аж үйлдвэрийн яамны саналыг зарчмын хувьд зөвшөөрч, төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх, мөн хөрөнгө оруулагчийг сонгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг тус яаманд даалгасан.</p>	50

	<p><b>Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> 2016-02-01</p> <p>1 Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд жилд 2.3 сая тонн хүртэл газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгасугай:</p> <p>1/ төсөл хэрэгжүүлэх үндэсний компанийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалтыг 2016 оны I улиралд багтаан зохион байгуулах;</p> <p>2/ уралдаант шалгаруулалтад шалгарсан хөрөнгө оруулагчтай улсын захиалгаар хийсэн газрын тос боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр үйлдвэр барьж ашиглалтад оруулах, ажиллуулах талаар хэлэлцээ хийж, гэрээ байгуулах;</p> <p>3/ газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих барилгын ажлыг энэ оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авах.</p>	<p>1/ Засгийн газрын 75 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Говийн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх Үндэсний компани(ууд)-ийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалт”-ыг Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 дугаар тушаалаар зарлан явуулсан. Энэхүү уралдаант шалгаруулалтад үндэсний болон олон улсын компаниуд хамтарсан нийт 4 консорциум материал ирүүлсэн. Уралдаант шалгаруулалтад оролцсон эдгээр консорциумуудын материалыг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүлээж авахаар төлөвлөж байсан боловч, уралдаант шалгаруулалтын оролцогч консорциумын гишүүн болох “Интер стандарт нефть” ХХК-иас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу шүүх 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 3792 дугаар захирамжаар захиргааны хэрэг үүсгэж, шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 дугаар тушаалын биелэлтийг түтгэлзүүлэх шийдвэр гаргасан тул сонгон шалгаруулалт явагдаагүй болно.</p>	70
7	<p><b>Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> 2016-02-01</p> <p>9 3 Газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай.</p>	Биелэлт ирүүлээгүй.	0
	<p><b>Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b> 2016-02-01</p> <p>10 4 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан үйлдвэрийг барих талбайн хэмжээ, газрын тос дамжуулах хоолой барих трассыг тогтоож, шаардагдах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг боловсруулж зохих журмын дагуу Засгийн газарт оруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.</p>	Урьдчилсан ТЭЗҮ-ээр Чойр, Сайншанд, Бор-Өндөр, Чойбалсан зэрэг байршлууд дээр судалгаа хийж боловсруулах үйлдвэрийг газрын тосны ордын байршил, дэд бүтэц, түүхий тос болон бэлэн бүтээгдэхүүний логистик, зах зээлд ойр байх гэсэн үзүүлэлтээр харьцуулан судалж, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байгуулахаар сонгосон. Энэ ажлын хүрээнд Аж үйлдвэрийн сайд /хуучнаар/, Аж үйлдвэрийн яамны холбогдох нэгж Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд 2016 оны 02 дугаар сард албан томилолтоор ажиллан аймаг, орон нутгийн удирдлагуудтай уулзаж, үйлдвэр барихаар төлөвлөсөн 3-н газрыг урьдчилсан байдлаар сонгож эдгээр сонгосон талбай дээр давхардуулан газар олгохгүй байх тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгосон.	50

8	<p>11 <b>Төслийн нэгж байгуулах тухай</b> 2016-09-28</p> <p>2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийн нэгж болон одоо үйл ажиллагаа явуулж байгаа Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт үүрэг болгосугай</p>	<p>УУХҮ-ийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн тушаалаар "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг байгуулан ажиллаж байна.</p> <p>Мөн УУХҮ-ийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 13 -ны өдрийн А/71 тоот тушаал гарч "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн нэгж"-ийн захирлыг томилсон. Тус төсөл хэрэгжүүлэх нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтэц орон тоо, төсвийг УУХҮЯ-ны ТНБ-аар батлуулан, төсвийн саналаа Сангийн яаманд хүргүүлэн, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.</p>	100
<b>Ерөнхий сайдын захирамж</b>			
1	<p>1 <b>Ажлын хэсэг байгуулах тухай "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах</b> 2016-11-22</p> <p>2 Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай</p>	<p>Засгийн газрын 2016 оны 107 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/43 дугаар тушаалаар "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан ажиллаж байна..</p> <p>Энэхүү төсөл хэрэгжүүлэх нэгж нь Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр, хий дамжуулах хоолойн бүтээн байгуулалттай холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллах бөгөөд үйлдвэрийн урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн эцсийн тайланг 2017 оны нэгдүгээр улиралд, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний эцсийн тайланг 2017 оны хоёрдугаар улиралд багтаан тус тус Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компаниудаас тус тус хүлээн авна.</p>	/-/
1	<p>2 <b>Ажлын хэсэг байгуулах тухай "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах</b> 2016-11-22</p> <p>2 Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай.</p>	<p>УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн нэгж"-ийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг 2017 оны 9 дүгээр сард сонгон шалгаруулахаар тусгасан.</p>	/-/
<b>ҮАБЗ-ийн зөвлөмж</b>			
1	<p>1 <b>Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай</b> 2012-03-27</p> <p>1 2011 оны УИХ-ын 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын 3 дугаар зүйлийн 4.6-д "Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн судалгаа хийх, бүтээгдэхүүн худалдан авах болон төслийн санхүүжилтэд Засгийн газраас баталгаа гаргах асуудлыг судлах" заалтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, технологийн сонгон шалгаруулалтын зарчмыг баримталж, төсөл хэрэгжүүлэгчид бүтээгдэхүүн худалдан авах баталгаа гаргах</p>	<p>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2014 оны 1 дүгээр сард нүүрснээс шингэн түлш гаргах төслийг ХБНГУ-ын технологийг ашиглан хэрэгжүүлэх тухай ЗГ-ын 246 тоот тогтоолын дагуу төсөл хэрэгжүүлэгч "СИ ТИ ЭЛ Монголиа" 100% төрийн өмчит компанийг байгуулсан. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын ҮХААЯамны санаачилгаар, 2014 оны 04 дүгээр сард төсөл хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийн 49 хүртэл хувийг хувийн хэвшлийнхэнд санал болгосон. Санал болгосон хувийн дагуу ХБНГУ-ын "GME Energy Generation" ХХК төсөлд хамтран ажиллах санал ирүүлэн Төрийн өмчийн хороо болон "GME Energy generation" ХХК-ын хооронд хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулагдаж, 51% Төрийн өмчит "ГерМон газ" ХХК байгуулагдсан. Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд зааснаар эхлээд төсөл хөгжүүлэх шатанд "ГерМон газ" ХХК нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад итгэмжлэгдсэн төслийн үнэлгээ /project due diligence/ бүхий судалгааны ажил хийж, банкинд итгэмжлэгдсэн ТЭЗҮ /bankable Feasibility study/ боловсруулах үүрэг хүлээсний дагуу "ГерМон газ" ХХК нь ХБНГУ-ын нүүрс хийжүүлэх технологи болох "Lugri Fixed Bed Dry Bottom Process" болон нийлэг хий шингэрүүлэх "Fischer@Tropsch" технологиудыг ашиглан Шивээ-Овоогын ордын нүүрснээс жилд 650 мянган тонн бензин, 84 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан.</p>	90

	<p><b>Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай</b> 2012-03-27</p> <p>2 Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх талаар аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачлага, төслийн хэрэгжилтийн явц, холбогдох баримт бичгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;</p>	<p>“MCS”, “МАК”, , “Си Ти Эл” ХХК-иуд Нүүрсийг гүн боловсруулж, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх ТЭЗҮ боловсруулж, Уул уурхайн яамны Эрдэс баялагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. “MCS” ХХК нь БНСУ-ын “Rosco” компанитай энэ төсөл дээр хамтран ажиллах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр гэрээ хэлэлцээрийг хийж дуусгаад байна. “МАК Си Ти Эл” ХХК нь мөн санхүүжилтийн асуудлаар БНХАУ, Герман улсуудын хөрөнгө оруулагчидтай яриа хэлэлцээрийг хийж байна. “Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК нь нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан ба санхүүгийн асуудал шийдэгдээгүй байна.</p>	50
2	3	<p><b>Газрын тос боловсруулах үйлдвэрийн тухай</b> 2014-03-17</p> <p>1 Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах.</p> <p>А/ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан 2014 оны 04 дүгээр сарын 14/06 тоот зөвлөмжийн дагуу Засгийн газраас 2015 оны 113 дугаар “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан. Тус тогтоолд “Жилд 2 сая хүртэл тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Говийн бүсэд, гурван зуун мянган тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Зүүн бүсэд байгуулах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх” болон шаардагдах зардлыг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Говийн бүсэд газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ зохион байгуулж, улмаар тендерт шалгарсан БНУнгар Улсын “ЕВРОЙЛ” ХХК болон түүний туслан гүйцэтгэгч “Бинамикс” ХХК компанитай 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан.</p> <p>Уг Гэрээний дагуу Унгар улсад бүртгэлтэй Евройл компани “Говийн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл”-ийг 2015 оны 7-р дугаар сараас 2016 оны 2 дугаар сарын хооронд боловсруулж бэлэн болгосон. Урьдчилсан ТЭЗҮ-ийг Аж үйлдвэрийн яамны /хуучнаар/ Хүнд үйлдвэрийн салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авч Засгийн газарт танилцуулсан.</p> <p>Б/ “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн урьдчилсан ТЭЗҮ-н дээр үндэслэн Засгийн газраас 2016 оны 75 дугаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих зарим арга хэмжээний тухай” тухай тогтоол гарсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Говийн бүсэд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх Үндэсний компани(ууд)-ийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалт”-ыг зарлах шийдвэрийг Аж үйлдвэрийн сайдын /хуучнаар/ 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 дугаар тушаал гарсан. Уг уралдаант шалгаруулалтад үндэсний болон олон улсын компаниуд хамтарсан нийт 4 консорциум материал ирүүлсэн. Уралдаант шалгаруулалтад оролцсон эдгээр консорциумуудын материалыг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүлээж авахаар төлөвлөж байсан боловч, уралдаант шалгаруулалтын оролцогч консорциумын гишүүн болох “Интер стандарт нефть” ХХК-иас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу шүүх 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 3792 дугаар захирамжаар захиргааны хэрэг үүсгэж, шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 дугаар тушаалын биелэлтийг түтгэлзүүлэх шийдвэр гаргасан тул сонгон шалгаруулалт хийгдээгүй болно.</p>	70
<b>ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл</b>			



1	1	<p><b>"Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийн тухай 2014-08-18</b></p> <p>1 БНХАУ-тай "нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхэдээ Монгол Улс, БНХАУ-ын хоёр талын хувь оролцоо адил тэнцүү хэмжээтэй байх, талууд өөрт оногдох оролцооны хүрээнд хөрөнгө оруулагч, мэргэжлийн багийг татан оролцуулах эрх нээлттэй байх зарчмыг баримтлах.</p> <p>2 Нүүрс боловсруулах химийн үйлдвэрүүдийг ажиллуулахад шаардлагатай дэд бүтэц болох хий болон ус дамжуулах хоолойг 100 хувь төрийн эзэмшилд байлгах зарчмыг баримтлах.</p> <p>3 Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газруудын зүгээс уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон татварын орчинг бүрдүүлж, бүтээгдэхүүний үнэ, борлуулалтын хугацаа, ажиллах хүч зэрэг нөхцөл, шаардлагыг Монгол Улсын эрх ашиг, олон улсын жишигт нийцүүлэх зарчмыг баримталж ажиллах.</p> <p>4 Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотыг хийгээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг нэн тэргүүнд бүрдүүлэх эхний үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг шуурхай боловсруулах.</p> <p>5 Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх химийн үйлдвэрүүдийг байгуулах гэрээ хэлэлцээрийг хоёр талын холбогдох яамдын түвшинд байгуулах.</p>	<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын дарга БНХАУ-д 2014 оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын үеэр "Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийн талаар талууд харилцан санал солилцсон. Эхний ээлжинд жилд 500 сая метр куб хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2 жилийн хугацаанд байгуулж, Улаанбаатар хотыг хийгээр хангаж, хотын агаарын бохирдлыг бууруулах саналтай байгаагаа Монгол Улсын Их хурлын дарга БНХАУ-ын дарга Си Зиньпин болон Синопек корпорацийн удирдлагуудтай хийсэн уулзалтууд дээр илэрхийлсэн. Түүнчлэн жилд 16 тэрбум метр куб байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төслийг үргэлжлүүлэх, БНХАУ-тай хий худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг урьдчилан байгуулах тухай саналуудыг тус тус гаргасан.</p> <p>Жилд 16 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр нь 5-8 жилд баригдах тул тус төслийн нэгжээс Улаанбаатар хотын гэр хорооллыг богино хугацаанд нүүрсний хийгээр хангаж, агаарын бохирдлыг бодитой бууруулах "Улаанбаатар хотын гэр хорооллыг хангах Нүүрсний хийн үйлдвэр" ба "Улаанбаатар хотын Хийн хангамж" төслийг санаачилж, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх хүсэлтийг гаргасан. Энэхүү ажлын хүрээнд 013 оны 03 дугаар сарын 30-ны өдөр баталсан БНХАУ-ын Засгийн Газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хавсралтад энэхүү төслийг оруулж, 162 сая ам.доллаар "ДЦС-2" ХК-ийг түшиглэн байгуулахаар 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газрын 135 тоот тогтоол гарсан.</p> <p>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төслийн нэгж БНХАУ-ын Хийн хоолойн зураг төслийн байгууллагуудтай хамтран 2015 оны 3-7 дугаар сарын хооронд Улаанбаатар хотын гэр хорооллыг нүүрсний хийгээр хангах үйлдвэрийн ТЭЗҮ болон нүүрсний хий дамжуулах хоолойн байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос үйлдвэр барихаар санал болгосон 3 компанийн дунд сонгон шалгаруулалт зарлахаар холбогдох бэлтгэл ажлуудыг хангасан.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас БНХАУ-аас олгох хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтаар Хөшигтийн хөндийн хурдны замын төслийг хэрэгжүүлэх нь илүү чухал ач холбогдолтой гэж үзэн Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор уг төслийн санхүүжилтийг "Улаанбаатар Хөшигтийн хөндийн хурдны зам барих төсөл", "Туул гол дээгүүр яван өнгөрөх Баянзүрхийн 288 у/м болон Сонсголгонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл"-д олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>Төслийн нэгж 2014 онд БНХАУ-ын Синопек компанитай хамтын ажиллагааны хүрээнд Багануурын уурхай дээр 1-3 тэрбум шоо м3 синтетик хий үйлдвэрлэх үйлдвэр барих хувилбарыг хэлэлцэн, техник, эдийн засгийн судалгаа хийж тооцоолсны үндсэн дээр Багануурын нүүрсний уурхайг түшиглэн барих үйлдвэр нь эдийн засгийн хувьд ашиггүй, Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш болохыг баталж, цаашид хэлэлцээрийг 2014 оны 8 дугаар сард хамтран гүйцэтгэж дууссан урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо м3 хүчин чадалтай нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих нөхцөлөөр үргэлжлүүлэхийг хүссэн.</p> <p>2015 оны 11 сард Синопек корпорацийн удирлага солигдсоноор энэхүү төслийг үргэлжлүүлэх боломжгүй талаар БНХАУ-ын тал мэдэгдэж Засгийн газрын 2016 оны 2 сарын 26-ны өдрийн 131-р тушаалаар төслийн нэгжийг татан буулгасан.</p>	70
---	---	--	---	----

















